



**МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ**

2013 оны 09 сарын 13 өдөр

Дугаар A/352

Улаанбаатар хот

Тушаалд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24.2 дахь хэсэг, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8.7 дахь хэсэг, Засгийн газрын 2012 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2012 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн “Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад суралцуулах тухай” А/334 дүгээр тушаалын Цогбадрах овогтой Цэнгүүнд холбогдох хэсгийн “Дартмоут дэх Массачуссетийн их сургуульд” гэснийг “Вашингтоны их сургуульд” гэж, 2012 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн “Сургалтын төрийн сангийн зээлээр гадаадад суралцуулах тухай” А/348 дугаар тушаалын Базарбямба овогтой Нямсурэнд холбогдох хэсгийн “Виржиний олон улсын их сургуульд” гэснийг “Стратфордын их сургуульд” гэж, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2012 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн “Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад суралцуулах тухай” А/213 дугаар тушаалын Байгалмаа овогтой Цогтод холбогдох хэсгийн “барилгын инженерийн чиглэлээр” гэснийг “физикийн чиглэлээр” гэж, 2013 оны 8 дугаар сарын 8-ны өдрийн “Гадаадад сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулах тухай” А/278 дугаар тушаалын Дүгээ овогтой Отгонтуяад холбогдох хэсгийн “Австрали Улсын Монаш их сургуульд” гэснийг “Финлянд Улсын Җамперийн их сургуульд” гэж, мөн тушаалын Зоригтбаатар овогтой Баяртотгоход холбогдох хэсгийн “1 жилийн хугацаатайгаар” гэснийг “2 жилийн хугацаатайгаар гэж тус тус өөрчилсүгэй.

2. Суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Б.Мөнхцэцэг/-д, энэхүү тушаалын

биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дээд боловсролын хэлтэс /П.Эрхэмбулган/-т тус тус даалгасугай.



Л.ГАНТӨМӨР